САНХҮҮГИЙН ЗОХИЦУУЛАХ ХОРОО

Засгийн газрын 4 дүгээр байр, Бага тойруу-3,
Чингэлтэй дүүрэг, Улаанбаатар хот, 15160
Утас: (976-51) 26 44 44, Факс: (976-51) 26 41 24,
Цахим шуудан: info@frc.mn, Цахим хуудас: www.frc.mn

2025.10.01 № 9/3643

танай _____-ны №_____-т

ЗОХИЦУУЛАЛТТАЙ ЭТГЭЭДҮҮДЭД

Үүрэг даалгавар хүргүүлэх тухай

Санхүүгийн зохицуулах хорооноос олгосон зөвшөөрөл, бүртгэлтэй этгээдүүд нь хөрөнгө оруулагч, үйлчлүүлэгчдэд санхүүгийн үйлчилгээ үзүүлэхдээ холбогдох хүний хувийн мэдээллийг цуглуулж, боловсруулж, ашигладаг тул Хүний хувийн мэдээлэл хамгаалах тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.8-д зааснаар мэдээлэл хариуцагчид тооцогддог.

Хүний хувийн мэдээлэл хамгаалах тухай хуулийн 22 дугаар зүйлийн 22.5, 22.6-д зааснаар мэдээлэл хариуцагч нь зөрчил, түүний сөрөг үр дагаврыг арилгах талаар авсан хариу арга хэмжээний тухай бүртгэл хөтөлж, бүртгэлийг жил бүрийн нэгдүгээр сард Хүний эрхийн Үндэсний Комисст хүргүүлэх, мөн түүний шаардсанаар тухай бүр хүргүүлэх зохицуулалттай.

Иймд хүний хувийн мэдээллийг цуглуулах, боловсруулах, ашиглах явцад илэрсэн зөрчил, түүний сөрөг үр дагаврыг арилгах талаар авсан хариу арга хэмжээний бүртгэл хөтөлж, хуульд заасан хугацаанд багтаан Хүний эрхийн Үндэсний Комисст хүргүүлж, хуулийн хэрэгжилтийг хангаж ажиллахыг үүгээр үүрэг болгож байна.

Дээрх үүргийн хэрэгжилтийг 2026 оны 01 дүгээр сарын 10-ны дотор хангаж, холбогдох мэдээллийг тус Хороонд давхар ирүүлэхийг анхааруулж байна.

Хавсралтаар “Хүний хувийн мэдээлэл хамгаалах тухай хуульд заасан зөрчлийг мэдэгдэх тухай зөвлөмж, Зөрчлийн бүртгэлийн маягт”-ыг хүргүүлж байна.

Хавсралт: 7 хуудастай.

ХЯНАЛТ ШАЛГАЛТ, ЗОХИЦУУЛАЛТЫН
ГАЗРЫН ДАРГЫН ҮҮРГИЙГ ТҮР
ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ Б.ДОЛГОРСҮРЭН

9025051491 CTC5900 5043239

1518006703

МОНГОЛ УЛСЫН
ХҮНИЙ ЭРХИЙН
ҮНДЭСНИЙ КОМИСС

Заавар:

Хүний хувийн мэдээлэл хамгаалах тухай хуульд заасан зөрчлийг мэдэгдэх, зөвлөмж авах нь

Энэхүү зааврыг мэдээлэл хариуцагч дараах үүргээ илүү сайн ойлгох, хэрэгжүүлэхэд туслах зорилгоор бэлтгэв:

- *мэдээлэл цуглуулах, боловсруулах, ашиглахад илэрсэн зөрчлийн талаар мэдээллийн эзэнд мэдэгдэх,*
- *зөрчил, түүний сөрөг үр дагаврыг арилгах талаар авсан хариу арга хэмжээний тухай бүртгэл хөтөлж, бүртгэлийг жил бүрийн нэгдүгээр сард Хүний эрхийн Үндэсний Комисст хүргүүлэх ба түүний шаардсанаар тухай бүр хүргүүлэх.*

2023 он

Агуулга

Мэдээлэл хариуцагч гэж хэн бэ? 3
Зөрчлийг хэнд мэдэгдэх вэ? 3
Зөрчилд юу хамаарах вэ? 3
Хүний хувийн мэдээлэл гэдэгт юу хамаарах вэ? 4
Хэзээ зөрчлийн талаар Комисст мэдэгдэх вэ? 4
Бүх зөрчлийн талаар мэдэгдэх үү? 4
Мэдээллийн эзэнд зөрчлийн талаар ямар мэдээлэл өгөх вэ? 4
Комисст өгөх бүртгэлд ямар **мэдээлэл тусгах вэ?** 5
Зөрчлийн бүртгэлийн маягт 6

Мэдээлэл хариуцагч гэж хэн бэ?

Хүний хувийн мэдээлэл хамгаалах тухай хуулийн 4.1.8-д зааснаар "мэдээлэл хариуцагч" гэж хуульд заасны дагуу, эсхүл мэдээллийн эзний зөвшөөрлийн дагуу мэдээлэл цуглуулж, боловсруулж, ашиглаж байгаа хүн, хуулийн этгээд, хуулийн этгээдийн эрхгүй байгууллагыг хэлнэ.

Зөрчлийг хэнд мэдэгдэх вэ?

Хүний хувийн мэдээлэл хамгаалах тухай хуулийн 22.1-т зааснаар мэдээлэл боловсруулагч нь мэдээлэл хариуцагчид, 22.2-т зааснаар мэдээлэл хариуцагч нь мэдээллийн эзэнд, 22.6-д зааснаар Хүний эрхийн Үндэсний Комисст мэдээлэл цуглуулах, боловсруулахад илэрсэн зөрчил, түүний сөрөг үр дагаврыг арилгах талаар авсан хариу арга хэмжээний тухай тус тус мэдэгдэнэ.



Тодруулбал, мэдээлэл хариуцагч нь мэдээллийн эзэнд болон Хүний эрхийн Үндэсний Комисст мэдэгдэх хоёр үүрэгтэй байна.

Мэдээлэл боловсруулагч гэдэг нь мэдээлэл хариуцагчийн өмнөөс мэдээлэл боловсруулж буй этгээд юм. Мэдээлэл хариуцагч нь мэдээлэл цуглуулах, боловсруулах үүргийг гэрээний үндсэн дээр мэдээлэл боловсруулагчид шилжүүлж болно. Энэ тохиолдолд мэдээлэл хариуцагч нь мэдээллийн эзний өмнө хүлээсэн үүрэг, хариуцлагаас чөлөөлөгдөхгүй.

Зөрчилд юу хамаарах вэ?

Мэдээлэл цуглуулах, боловсруулахад илэрсэн зөрчил буюу хүний хувийн мэдээллийг хамгаалаагүй зөрчил гэдэгт Хүний хувийн мэдээлэл хамгаалах тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-т заасан мэдээлэл цуглуулах, боловсруулах, ашиглахад баримтлах зарчмыг алдагдуулсан буюу хувийн мэдээллийг алдах, өөрчлөх, задруулах, устгах, зөвшөөрөлгүй үзэхэд хүргэсэн зөрчлийг ойлгоно.

Хүний хувийн мэдээллийг хамгаалаагүй зөрчил гэдэг зөвхөн хувийн мэдээллийг алдахаас илүү өргөн хүрээтэй гэдгийг мэдээлэл хариуцагч мэдэж байх ёстой. Тодруулбал, энэ зөрчилд хүний хувийн мэдээллийн зөрчилд мэйл, шууданг буруу хүлээн авагч руу явуулах зэрэг алдаа, будилаан болон хэрэглэгчийн мэдээлэлд нэвтрэхийн тулд фишинг халдлага үйлдэх гэх мэт санаатай үйлдэл аль аль нь хамаарна.

Хүний хувийн мэдээлэл гэдэгт юу хамаарах вэ?

Хүний хувийн мэдээлэл хамгаалах тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.11-т зааснаар "хүний хувийн мэдээлэл" гэж хүний эмзэг мэдээлэл болон хүний эцэг /эх/-ийн нэр, өөрийн нэр, төрсөн он, сар, өдөр, төрсөн газар, оршин суугаа газрын хаяг, байршил, иргэний бүртгэлийн дугаар, хөрөнгө, боловсрол, гишүүнчлэл, цахим тодорхойлогч, хүнийг шууд болон шууд бусаар тодорхойлох, эсхүл тодорхойлох боломжтой бусад мэдээллийг хэлнэ.

Мөн хуулийн 9 дүгээр зүйлийн 9.1-т зааснаар эрүүл мэнд, захидал харилцаа, генетик болон биометрик мэдээлэл, тоон гарын үсгийн хувийн түлхүүр, бэлгийн болон хүйсийн чиг баримжаа, илэрхийлэл, бэлгийн харьцааны талаарх хүний эмзэг мэдээлэл нь хувь хүний нууцад хамаарна.

Хэзээ зөрчлийн талаар Комисст мэдэгдэх вэ?

Хүний хувийн мэдээлэл хамгаалах тухай хуулийн 22 дугаар зүйлийн 22.5, 22.6-д зааснаар мэдээлэл хариуцагч нь зөрчил, түүний сөрөг үр дагаврыг арилгах талаар авсан хариу арга хэмжээний тухай бүртгэл хөтөлж, бүртгэлийг жил бүрийн нэгдүгээр сард Хүний эрхийн Үндэсний Комисст хүргүүлэх ба түүний шаардсанаар тухай бүр хүргүүлнэ.

Энэ нь мэдээллийн эзний эрх, хууль ёсны ашиг сонирхолд хохирол учруулах хэмжээний аливаа зөрчил гарсан даруйд Хүний эрхийн Үндэсний Комисст бүртгэлээр дамжуулан мэдэгдэх үүрэгтэй болохыг илэрхийлж байна. Ингэхдээ тухайн зөрчил гарсан буюу түүнийг мэдээлэл хариуцагч мэдсэнээс хойш боломжит богино хугацаанд мэдэгдэх шаардлагатай. Ийнхүү мэдэгдэж чадаагүй тохиолдолд тийнхүү хойшлуулсан үндэслэлийн талаар мэдэгдвэл зохино. Боломжит богино хугацаанд зөрчлийн талаарх бүх мэдээллийг өгөх буюу мэдэгдэх боломжгүй тохиолдолд урьдчилсан мэдээллийг өгөх боломжтой.

Бүх зөрчлийн талаар мэдэгдэх үү?

Хүний хувийн мэдээлэл хамгаалах тухай хуулийн 22 дугаар зүйлийн 22.2-т зааснаар мэдээллийн эзний эрх, хууль ёсны ашиг сонирхолд хохирол учруулах хэмжээний зөрчлийг мэдэгдэнэ.

Энд дурдсан хохирол учруулах хэмжээний зөрчил мөн эсэхийг мэдээлэл хариуцагч нь зохих дүн шинжилгээ, үнэлгээ хийсний үндсэн дээр тодорхойлно. Мэдээллийн эзэн ба Хүний эрхийн Үндэсний Комисст мэдэгдэх шаардлагагүй тохиолдлын талаарх бүртгэлийг мэдээлэл хариуцагч тухай бүр хөтөлнө. Энэ бүртгэлд авсан арга хэмжээний талаар тусгана.

Мэдээллийн эзэнд зөрчлийн талаар ямар мэдээлэл өгөх вэ?

Хүний хувийн мэдээлэл хамгаалах тухай хуулийн 22 дугаар зүйлийн 22.3-т зааснаар мэдээллийн эзэнд өгөх мэдэгдэл дараах мэдээллийг агуулсан байна:

1. зөрчилд хамаарах мэдээллийн эзэн, мэдээллийн бүртгэл;

2. мэдээлэл хариуцагчийн нэр, холбоо барих мэдээлэл;
3. зөрчил, түүний улмаас учирч болзошгүй сөрөг үр дагавар;
4. зөрчил, түүний улмаас учирч болзошгүй сөрөг үр дагаврыг арилгах талаар авсан хариу арга хэмжээ.

Энд дурдсан зөрчлийн улмаас учирч болзошгүй сөрөг үр дагаврыг арилгах талаар авсан хариу арга хэмжээ гэдэгт техникийн болон зохион байгуулалтын шинжтэй хамгаалалтын арга хэмжээг ойлгоно. Тухайлбал, хувийн мэдээллийг шифрлэх зэргээр мэдээлэлд хандах эрхгүй аливаа этгээд мэдээлэлд нэвтрэхээс сэргийлэх арга хэмжээ хамаарна.

Комисст өгөх бүртгэлд ямар мэдээлэл тусгах вэ?

Хүний хувийн мэдээлэл хамгаалах тухай хуулийн 22 дугаар зүйлийн 22.5, 22.6-д зааснаар мэдээлэл хариуцагч нь зөрчил, түүний сөрөг үр дагаврыг арилгах талаар авсан хариу арга хэмжээний тухай бүртгэл хөтөлж, бүртгэлийг жил бүрийн нэгдүгээр сард Хүний эрхийн Үндэсний Комисст хүргүүлэх ба түүний шаардсанаар тухай бүр хүргүүлнэ.

Энэхүү бүртгэлд дараах мэдээллийг тусгана:

1. зөрчлийн агуулгыг тайлбарласан байх. Ингэхдээ боломжтой бол холбогдох мэдээллийн эзний талаар болон хувийн мэдээллийн төрөл, хэлбэр, тоог багтаах
2. хувийн мэдээлэл хамгаалах ажилтан болон нэмэлт мэдээлэл авч болох бусад этгээдийн нэр, холбоо барих хаяг
3. зөрчлийн болзошгүй үр дагаврыг тайлбарласан байх
4. зөрчлийг арилгахын тулд мэдээлэл хариуцагчаас авсан эсвэл авахаар төлөвлөж буй арга хэмжээ.

Энэ хүрээнд “Мэдээлэл хариуцагчаас Хүний эрхийн Үндэсний Комисст хүргүүлэх бүртгэлийн маягт”-ыг ашиглах боломжтой.

Зөрчлийн бүртгэлийн маягт

Мэдээлэл хариуцагчаас Хүний эрхийн Үндэсний Комиссын dataprotection@nhrcm.gov.mn хаягт хүргүүлэх бүртгэлийн маягт

1/ Мэдээлэл хариуцагчийн мэдээлэл

1.1	нэр:	*бичих*
1.2	хаяг, холбоо барих мэдээлэл:	*бичих*
1.3	мэдээлэл хамгаалах ажилтны нэр, холбоо барих мэдээлэл /утас, цахим шуудан/:	*бичих*
1.4	Бүртгэлд хамаарах хугацаа	*бичих*

2/ Хувийн мэдээллийн зөрчлийн талаарх ерөнхий мэдээлэл

1.1	Бүртгэлд хамаарах хугацаанд хувийн мэдээллийн зөрчил гарсан	+
1.2	Бүртгэлд хамаарах хугацаанд хувийн мэдээллийн зөрчил гараагүй	+

3/ Зөрчлийн талаарх дэлгэрэнгүй мэдээлэл

1. Зөрчлийн талаар мэдсэн байдал			
1.1	Зөрчил гарсан болохыг мэдсэн эсэх		*Тийм/Үгүй*
1.2	Зөрчил үргэлжилж буй эсэх		*Тийм/Үгүй*
1.3	Зөрчлийн огноо /зөрчил болсныг мэдсэн огноо/		*2023.01.31*
1.4	Зөрчлийн талаар боломжит богино хугацаанд Комисст мэдэгдээгүй бол түүний үндэслэл, тайлбар		*бичих*
1.5	Мэдээлэл хариуцагч зөрчлийн талаар хэрхэн мэдсэн бэ		*сонгох буюу бичих*
	1.5.1	Мэдээллийн эзэн мэдэгдсэн	+
	1.5.2	Гуравдагч этгээд мэдэгдсэн	+
	1.5.3	Системд аудит хийх, туршилт хийхэд	+
	1.5.4	Мэдээлэл боловсруулагч мэдэгдсэн	+
	1.5.5	Ажилтан мэдэгдсэн	+
	1.5.6	Бусад	*бичих*
2. Зөрчлийн төрөл			
2.1	Хувийн мэдээллийг алдах, устгах		+
2.2	Хувийн мэдээлэл агуулсан төхөөрөмжийг гээх, алдах		+
2.3	Цаасан мэдээллийг гээх, алдах		+
2.4	Дүрс бичлэгийн төхөөрөмж дэх зураг, бичлэг, хувийн мэдээллийг задруулах		+
2.5	Цахим шуудан дахь хувийн мэдээллийг задруулах		+
2.6	Зурвас/чат дахь хувийн мэдээллийг задруулах		+
2.7	Олон нийтийн сүлжээн дэх хувийн мэдээллийг задруулах		+
2.8	Захидал, илгээмж дэх хувийн мэдээллийг задруулах		+
2.9	Цаасан болон цахим бүртгэл дэх хувийн мэдээллийг задруулах		+
2.10	Хувийн мэдээллийг аман хэлбэрээр задруулах		+
2.11	Цахим хог хаягдал, хуучирсан төхөөрөмж дэх хувийн мэдээлэл алдагдах		+
2.12	Кибер халдлагад өртөх		+
2.13	Хувийн мэдээллийг зөвшөөрөлгүй өөрчлөх		+
2.14	Хүний хувийн мэдээллийг боловсруулах үед алдаа гаргах		+
2.15	Хувийн мэдээллийг зөвшөөрөлгүй нийтлэх, олон нийтэд түгээх		+
2.16	Системийн засвар үйлчилгээний явцад зөрчил гарах		+
2.17	Бусад		+
Болсон зөрчлийг дэлгэрэнгүй тайлбарлана уу			*бичих*
3. Зөрчилд хамаарах хувийн мэдээллийн төрөл			
3.1	Овог, нэр, төрсөн он, сар, өдөр,		+

3.2	Төрсөн газар, оршин суугаа газрын хаяг, байршил		+
3.3	Холбоо барих мэдээлэл /утасны дугаар, мэйл хаяг, хаяг, шуудангийн код/		+
3.4	Иргэний албан ёсны баримт бичгийн мэдээлэл /иргэний бүртгэлийн дугаар, регистрийн дугаар, гадаад пасспортын дугаар/		+
3.5	Эдийн засаг, санхүүгийн мэдээлэл		+
3.6	Албан ёсны баримт бичгийн эх хувь, хуулбар		+
3.7	Таних, нэвтрэх мэдээлэл /хэрэглэгчийн нэр, нууц үг, таних дугаар/		+
3.8	Олон нийтийн цахим сүлжээний хаяг		+
3.9	Гишүүнчлэлийн мэдээлэл		+
3.10	Тухайн үеийн байршлын мэдээлэл /GPS байршлын мэдээлэл/		+
3.11	Гэрэл зураг, дүрс бичлэг, дуу бичлэг, тэдгээрийн бүртгэл		+
3.12	Хувийн болон гэр бүлийн амьдралтай холбоотой мэдээлэл		+
3.13	Мэргэжлийн үйл ажиллагаатай холбоотой мэдээлэл		+
3.14	Бусад		+
3.15	Хүний эмзэг мэдээлэл		
	3.15.1	Үндэс, угсааны мэдээлэл	+
	3.15.2	Шашин шүтлэг, итгэл үнэмшил	+
	3.15.3	Эрүүл мэндийн мэдээлэл	+
	3.15.4	Захидал харилцаа	+
	3.15.5	Генетик болон биометрик мэдээлэл	+
	3.15.6	Тоон гарын үсгийн хувийн түлхүүр	+
	3.15.7	Ял эдэлж байгаа болон ял эдэлсэн эсэх мэдээлэл	+
	3.15.8	Бэлгийн болон хүйсийн чиг баримжаа, илэрхийлэл, бэлгийн харьцааны талаарх мэдээлэл	+
4. Зөрчилд хамаарах мэдээллийн эзэн, мэдээллийн тоо			
4.1	Зөрчилд хамаарах мэдээллийн тоо		*сонгох*
	4.1.1	1-10	+
	4.1.2	11-100	+
	4.1.3	101-1000	+
	4.1.4	1001-10,000	+
	4.1.5	10,001-100,000	+
	4.1.6	100,001-1,000,000	+
	4.1.7	1,000,000-с дээш	+
	4.1.8	Тухайн үед тоо тодорхой бус байсан	+
4.2	Зөрчлийн улмаас хохирсон, хохирсон байж болзошгүй мэдээллийн эзний тоо		*сонгох*
	4.2.1	1-10	+
	4.2.2	11-100	+
	4.2.3	101-1000	+
	4.2.4	1001-10,000	+
	4.2.5	10,001-100,000	+
	4.2.6	100,001-1,000,000	+
	4.2.7	1,000,000-с дээш	+
	4.2.8	Тухайн үед тоо тодорхой бус байсан	+
4.3	Хүүхдийн талаарх мэдээлэл алдагдсан эсэх		*Тийм/Үгүй*
5. Зөрчлийн талаар авсан арга хэмжээ, үр дагавар			
5.1	Зөрчлийн улмаас сөрөг үр дагавар гарсан уу?		*Тийм/Үгүй*
5.2	Ямар сөрөг үр дагавар гарсан, гарах боломжтой вэ?		*бичих*
5.3	Зөрчлийн сөрөг үр дагаварыг бууруулах талаар арга хэмжээ авсан уу?		*Тийм/Үгүй*
5.4	Авсан арга хэмжээнийхээ талаар бичнэ үү?		*бичих*
5.5	Зөрчилд өртсөн мэдээллийн эзэнд энэ талаар мэдээлэл өгсөн үү?		*Тийм/Үгүй*
6. Хавсралт			
6.1	Холбогдох баримтыг хавсаргана уу		*Хавсаргах*